



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ᠰᠤᠬᠤᠪᠠᠭᠠᠲᠤ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠢᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠳᠡᠷᠭᠡᠳᠡᠬᠡ  
ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ  
ᠬᠡᠯᠲᠡᠰ

# АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2019/03



[sukhbaatar.nso.mn](http://sukhbaatar.nso.mn)

[www.1212.mn](http://www.1212.mn)



Статистикийн хэрэглэгч та бүхэн манай хэвлэмэл бүтээгдэхүүн болон тоо мэдээллүүдийг 1212.mn аппликейшнаар дамжуулан Apple-ын iPhone, iPad төхөөрөмжтэй бол App store-с, андройд үйлдлийн системийн төхөөрөмжтэй бол Google play-с татан авч, суулгаж ашиглах боломжтой.

# СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХААНААС, ХЭРХЭН АВАХ ВЭ ?

 Цахимаар:

**www.1212.mn**

Статистик мэдээллийн  
нэгдсэн сан

**www.sukhbaatar.nso.mn**

Сүхбаатар аймгийн статистик  
хэлтсийн вэб хуудас

**WWW.1212.MN** СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН



Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах  
тоглоом 


Валютын ханш 

©2017   

аппликейшнаас  
**СТАТИСТИКИЙН мэдээллээ аварай**



**www.nso.mn**

Та статистик мэдээллийг байнга  
авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ**  
бүртгүүлнэ үү 

Энэ хэсэгт өөрийн e-mail  
хаягаа бүртгүүлснээр  
статистикийн мэдээллийг  
цаг алдалгүй тогтмол авч  
байх болно.

**SOCIAL NETWORK**



[www.facebook.com/  
Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)



[www.twitter.com/  
statistic\\_mn](http://www.twitter.com/statistic_mn)

**СҮХБААТАР АЙМАГ**



[www.facebook.com/  
statistic](http://www.facebook.com/statistic)



Утсаар:



Лавлах утас

**1900-1212**

**Сүхбаатар аймаг**

**7051-8203**



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ,  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

**3 сар  
2019**

Баруун-Урт сум



## ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл .....	3
Аргачлалын тайлбар .....	4-5
Товч танилцуулга .....	6-15
Үндсэн үзүүлэлтүүд .....	16
<b>I. Нийгмийн үзүүлэлт</b>	
I.1 Хөдөлмөр .....	17-19
I.2 Нийгмийн даатгал, нийгмийн халамж .....	20-21
I.3 Эрүүл мэнд .....	22-23
I.4 Соёл, урлаг .....	24
I.5 Газар өмчлөл .....	25
I.6 Гэмт хэрэг .....	26-27
<b>II. Эдийн засгийн үзүүлэлт</b>	
II.1 Мөнгө, банк, даатгал .....	28-29
II.2 Төрийн санхүү .....	30-31
II.3 Үнэ .....	32-33
II.4 Хөдөө аж ахуй .....	34-37
II.5 Аж үйлдвэр .....	38-40



## Ерөнхий тэмдэглэл

### I. Товчилсон тэмдэглэлгээ:

Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

### II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухай сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв.

### III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

...	Мэдээлэл байхгүй	x	Бүтцийн өөрчлөлт
0.0	Маш бага тоо	+, -	Зөрүү
-	Гүйцэтгэл байхгүй	*	Дахин

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV.18-17 нь 2019 оны үзүүлэлтийн тухайн оны үзүүлэлтээс өсч, буурсан абсолют өөрчлөлт.

V. "Төл" нь төлөвлөгөөг, "Гүйц" нь гүйцэтгэл.

VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Тэтгэвэр, тэтгэмж:** Уг мэдээг нийгмийн даатгал, хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас нэгтгэж ирүүлдэг.
- **Эрүүл мэнд:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
  - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
  - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Соёл, урлаг:** Соёл, урлагийн үйл ажиллагааг эрхэлдэг газрууд нь мэдээг нэгтгэн гаргаж ирүүлдэг.
- **Газар өмчлөгч:** Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь сумдаас мэдээллийг авч нэгтгэн ирүүлсний дагуу мэдээллийг хүргэдэг.
- **Гэмт хэрэг:** Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатайгаар, болгоомжгүйгээ салах хэргийг нэгтгэн оруулсан.
- Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.



- Нийгмийн Аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
- 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Мөнгө, банк, даатгал:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг. Даатгалын үйлажиллагаа эрхэлдэг компаниуд үндсэн үйл ажиллагааны мэдээллийг гаргаж ирүүлдэг.
- **Төсөл:** Засгийн газрын зарим гол төслүүд болон сангуудын хөрөнгийн зээл олголт, үйл ажиллагааны мэдээллийг холбогдох хэлтэс, агентлагууд гаргаж ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ. Төсвийн мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.  
Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

**Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо:** гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

**Борлуулсан бүтээгдэхүүн нь** аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

**Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь** тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



**Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал  
(2019 оны 3 дугаар сарын байдлаар)**


**I. Нийгмийн үзүүлэлт**



**I.1. Хүн ам**

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2019 оны эхний 3 сард 280 хүүхэд шинээр мэндэлж, 87 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 193 болж өмнөх оны мөн үеэс 14.9 хувиар буюу 34-ээр буурсан.

Зураг.I.1.1 Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2016-2019 оны эхний 3 сард




**I.2 Хөдөлмөр**

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 3 сарын эцэст 854 болсны 415 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 665 нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оноос 64.2 хувь буюу 371 хүнээр буурчээ.

Эхний 1 улирлын байдлаар хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт 633 иргэн шинээр бүртгүүлсний 81 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Зураг I.2.1 Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо, жил бүрийн 3 сарын байдлаар





Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 58.1 хувь нь 15-34 насны залуучууд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.9 хувь нь магистр, доктор, 14.1 хувь нь бакалаврын дээд, 2.7 хувь нь тусгай дунд, 7.8 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 52.3 хувь нь бүрэн дунд, 13.5 хувь нь суурь, 6.5 хувь нь бага боловсролтой, 2.1 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Зураг 1.2.2 Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингээр, эхний 3 сарын байдлаар



Эхний 3 сарын байдлаар 56 шинэ ажлын байр бий болсон нь өмнөх оны мөн үеэс 37.1 хувь буюу 33-аар буурчээ. Шинэ ажлын байрыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл: бөөний болон жижиглэн худалдааны салбарт 31 буюу 55.4 хувийг эзэлж байгаа нь өндөр үзүүлэлтэй байна.



### 1.3 Нийгмийн даатгал, халамж:

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 4.1 тэрбум төгрөг болсон байна. Үүнээс сайн дурын даатгуулагчид 8.9 хувь болох 368.3 сая төгрөгийн шимтгэл оруулсан байна. Нийт 7.9 мянган иргэнд 7.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг бүрэн олгосон байна. Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.4 хувиар өссөн байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас эхний 3 сарын байдлаар давхардсан тоогоор 24.2 мянган иргэнд 2.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, тусламж, тэтгэмжийг олгожээ.




### I.4 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 1-р улирлын байдлаар 68.9 мянган хүнд үзлэг хийсэн нь 11.5 буюу 20 хувь, урьдчилан сэргийлэх үзлэгт 24.8 мянган хүн хамрагдсан нь 82.4 хувиар тус тус өсч, 3.5 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үетэй адил түвшинд байна.

Түргэн тусламжийн дуудлага 5.2 мянган удаа гарсны 1.1 мянга буюу 21.2 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 8.3 хувиар өсч, алсын дуудлага 8.3 хувиар буурсан байна.

Аймгийн хэмжээнд 278 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 280 болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 34 буюу 10.9 хувиар, хүүхдийн тоо 32 буюу 10.3 хувиар тус тус буурсан байна.

Зураг.I.4.1 Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2019 оны эхний 3 сарын байдлаар 274 болж, өмнөх оны мөн үеэс 70 буюу 34.3 хувиар өсөхөд салхинцэцэг өвчнөөр өвчлөгчдийн тоо 33 хүн буюу 35.5 хувь, тэмбүү өвчнөөр өвчлөгчдийн тоо 37 хүн буюу 2 дахин, заг өвчнөөр өвчлөгчдийн тоо 6 хүн буюу 30 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нялхсын эндэгдэл энэ оны эхний 3 сарын байдлаар 5 болж, өмнөх оны мөн үеэс 1 хүүхэд буюу 25.0 хувиар өсч, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл байхгүй байна.




### I.5 Соёл, урлаг:


**Хөгжимт жүжгийн театр:** 2.6 мянган үзэгчдэд 11 тоглолтоор үйлчилж 1.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс үзэгчдийн тоо 1.5 мянга буюу 36.6 хувиар буурчээ.



Зураг-I.5.1 Нийт тоглолтын тоо




Зураг-I.5.2 Нийт үзэгчдийн тоо, мян.хүн




**Музей:** 2.1 мянган үзмэрээр 0.6 мянган хүнд үйлчилж 291.5 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс үзэгчдийн тоо 64.7 хувиар буурч, үзмэрийн тоо 1.7 хувиар өссөн байна.

Зураг-I.5.3 Нийт үзмэрийн тоо, мянган ш




Зураг-I.5.4 Нийт үзэгчдийн тоо, мян.хүн




**Номын сан:** Нийт 46.8 мянган номоор 1.7 мянган уншигчдад үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс номын тоо 0.3 мянгаар өсч, уншигчдын тоо 0.1 мянгаар буурсан байна.

Зураг-I.5.5 Нийт номын тоо, мянган ш



Зураг-I.5.6 Нийт уншигчдын тоо, мян.хүн






### I.6 Газар өмчлөл:

Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 10.5 мянган иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 10.0 мянган иргэнд 902.8 га газар өмчлүүлэх шийдвэр гараад хэрэгжиж байна.

Эхний 3 сард аж ахуйн зориулалтаар газар өмчлөхийг хүссэн 25 иргэний өргөдөл ирсэнийг 100 хувь шийдвэрлэжээ.

Зураг-I.6.1 Газар өмчлөх өргөдөл гаргасан иргэдийн тоо



Зураг-I.6.2 Засаг даргын шийдвэр гарсан иргэдийн тоо



### I.7 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 3 сард 136 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 8 хүн нас барж, 36 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оныхоос 52.8 хувиар өссөн байна.


Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 365.1 сая төгрөгийн хохирол учирсны 19.4 хувийг нөхөн төлүүлжээ. Гэмт хэрэгт 55 хүн холбогдон сэжиглэгдсэний 56.4 хувь нь согтуугаар, 7.3 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлджээ.

Нийт 155 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 24 хүн буюу 18.3 хувиар өссөн байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 15 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 22.6 хувьтай байна.



Зураг I.7.1 Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



## II. Эдийн засгийн үзүүлэлт



### II.1 Мөнгө, банк, даатгал

**Монгол банкны мэдээгээр** ХААН, Төрийн, Хас, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 139.2 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 4.4 тэрбум төгрөг буюу 3.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 19.4 тэрбум төгрөг буюу 16.2 хувиар өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 82.0 тэрбум төгрөг болж, оны эхнээс 2.2 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 22.8 тэрбум төгрөгөөр өсчээ.

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл эхний 3 сарын эцэст 1.4 тэрбум болж оны эхнээс 0.8 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 0.4 тэрбум төгрөгөөр тус тус өсч, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.0 хувийг эзэлж байна.

Зураг.II.1.1 Зээлийн өрийн үлдэгдэл, хугацаа хэтэрсэн чанаргүй зээл, хадгаламжийн үлдэгдэл, сарын эцэст, тэрбум төг






**Даатгал:** Даатгалын байгууллагуудын хураамжийн орлого 36.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 39.5 хувиар өсчээ.

Эхний 1 дүгээр улирлын байдлаар 85 хүнд 18.3 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна. Нөхөн олговрыг төрлөөр нь авч үзвэл авто тээврийн хэрэгсэлд 3.5 сая, жолоочийн хариуцлагын даатгалд 10.0 сая, иргэдийн эд хөрөнгө, гэнэтийн ослын даатгалд 1.4 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 2.0 сая төгрөгийг тус тус олгожээ.

Зураг.II.1.2 Даатгалын төрлөөр



## II.2 Төрийн санхүү:


Аймгийн төсвийн нийт орлого эхний 3 сард 16.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.7 тэрбум төгрөг буюу 15.8 хувиар буурч, төсвийн зарлага санхүүжилт 13.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум төгрөг буюу 10.9 хувиар өсчээ.

Орон нутгийн төсөвт 2.1 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 44.0 хувиар буурсан гүйцэтгэлтэй гарчээ.

Эхний 1-р улирлын байдлаар Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 3.3 тэрбум төгрөг авсан нь өмнөх оны мөн үеэс 63.3 хувиар, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг 0.5 тэрбум төгрөг авсан нь өмнөх оны мөн үеэс 35.1 хувиар тус тус өсч, харин Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг 6.7 тэрбум төгрөг авсан нь өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар буурсан байна.




Зураг. II.2 Төсвийн орлого, зарлага, тэрбум.төг



### II.3 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс 2019 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 6.2 хувь, жилийн эцсээс 1.9 хувиар өслөө.





## Хүснэгт. II.3.1 Хэрэглээний үнийн индекс, 2019 оны 3 дугаар сар, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2019.III}{2018.III}$	$\frac{2019.III}{2018.XII}$	$\frac{2019.III}{2019.II}$
<b>Ерөнхий индекс</b>	<b>106.2</b>	<b>101.9</b>	<b>100.9</b>
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	107.9	106.4	102.3
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	102.4	102.7	100.5
Хувцас, бөс бараа, гутал	102.2	103.1	100.6
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	102.7	100.2	100.2
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	102.0	100.6	99.9
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	107.4	104.6	103.1
Тээвэр	105.5	98.8	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	104.8	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	102.4	101.0	100.3
Боловсролын үйлчилгээ	101.2	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	105.7	99.0	100.2
Бусад бараа, үйлчилгээ	102.7	101.3	100.3

**Ерөнхий индекс өмнөх сарынхаас 0.9 хувиар** өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 2.3 хувь, согтууруулах ундаа, тамхи, сансууруулах бодисын бүлгийн үнэ 0.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.6 хувь, орон сууц, ус, цахилгаан хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 0.2 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний үнэ 0.7 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 0.3 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 0.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

**II.4 Хөдөө аж ахуй**

**Мал төллөлт төл бойжилт.** Оны эхний төллөх насны хээлтэгч малын 13.8 хувь буюу 225.0 мянган хээлтэгч мал төллөсөн байна. Таван төрлөөр нь авч үзвэл: эм хонь 15.9 хувь, эм ямаа 14.2 хувь, үнээ 4.5 хувь, ингэ 5.6 хувь, гүү 1.7 хувь тус тус төллөжээ.

Гарсан төлийн 99.6 хувь болох 225.2 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 32.8 мянга буюу 17.0 хувиар өссөн байна.

3 дугаар сарын байдлаар төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл: хурга 99.7 хувь, ишиг 99.5 хувь, унага 98.8 хувь, тугал 98.7 хувь, ботго 99.4 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс унага, ишиг, тугал, хурга 0.1-0.2 пунктээр өссөн байна.



Зураг-II.4.1 Төллөсөн хээлтэгчийн тоо, сумаар, мян.толгой, 2019 оны эхний 3 дугаар сарын байдлаар




Зураг-II.4.2 Бойжуулсан төлийн тоо, сумдаар, мян.толгой, 2019 оны эхний 3 дугаар сарын байдлаар



**Малын онд оролт:** Том малын зүй бус хорогдол эхний 3 сарын байдлаар 3.2 мянган толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 29.9 мянган толгой буюу 90.2 хувиар буурсан байна. Том малын хорогдлыг төрлөөр нь авч үзвэл: тэмээ 5, адуу 232, үхэр 161, хонь 1.5 мянга, ямаа 1.3 мянган толгой байна.

Малын нийт хорогдлын 46.6 хувийг хонь эзэлж байна.

Зураг-II.4.3 Том малын зүй бусын хорогдол



Эхний 3 сарын байдлаар оны эхний малын 0.1 хувь нь хорогджээ. Нийт хорогдлын 0.2 хувь буюу 5 толгой мал нь өвчнөөр хорогдсон байна. Өмнөх оны мөн үеэс 94.4 хувиар буурчээ.



## II.5 АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2010 оны зэрэгцүүлэх үнээр 11.2 тэрбум төгрөг болж өмнөх оноос 2.7 тэрбум төгрөг буюу 19.4 хувиар буурчээ. Ангиллаар нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл: уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 9.8 тэрбум төгрөг буюу 22.4 хувиар буурч, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 1.14 тэрбум төгрөг буюу 0.6 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 0.3 тэрбум төгрөг буюу 42.9 хувиар тус тус өссөн байна.

Оны үнээр 83.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос 3.7 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс хүрэн нүүрс, бууз, банш, нарийн боов, хийжүүлсэн цэвэр ус, рашаан, хэрчсэн гурил, монгол дээл, гутал, хүрэм, модон сандал, төрөл бүрийн модон эдлэл зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс өссөн байна.

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ



## ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

	Хэмжих нэгж	2017	2018	2019	Зөрүү	$\frac{2019}{2018}$ %
<b>Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд</b>						
Төрсөн хүүхэд	хүн	281	312	280	- 32	89.7
Нялхасын эндэгдэл	хүн	5	4	5	1	125.0
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	993	1 036	665	- 371	64.2
Халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	515	204	274	70	134.3
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	89	89	136	47	152.8
Хэрэгт холбогсод	хүн	92	44	55	11	125.0
<b>Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт</b>						
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар						
Иргэдийн хадгаламж	сая.төг	44 903.1	59 159.5	82 013.2	22 853.7	138.6
Зээлийн өрийн үлдэгдэл	сая.төг	102 484.9	119 800.3	139 232.8	19 432.5	116.2
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	14 507.5	16 694.4	14 047.8	2 186.9	115.1
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	12 385.8	11 924.6	13 216.6	1 292.0	110.8
Төлөлсөн хээлтэгч	тол	193 285	191 466	225 013	33 547	117.5
-Ингэ	тол	184	236	179	- 57	117.5
-Гүү	тол	4 046	5 741	1 744	-3 997	75.8
-Үнээ	тол	4 918	7 984	4 341	-3 643	30.4
-Эм хонь	тол	121 955	115 182	141 541	26 359	54.4
-Эм ямаа	тол	62 182	62 323	77 209	14 886	122.9
Бойжуулсан төл	тол	193 839	192 380	225 178	32 798	117.0
-Ботго	тол	181	236	177	- 59	75.0
-Унга	тол	4 021	5 668	1 723	-3 945	30.4
-Тугал	тол	4 877	7 862	4 285	-3 577	54.5
-Хурга	тол	122 306	115 706	141 670	25 964	122.4
-Ишиг	тол	62 454	62 908	77 323	14 415	122.9
Том малын зүй бусын хорогдол	тол	7 226	33 139	3 234	-29 905	9.8
- Тэмээ	тол	6	4	5	1	125.0
- Адуу	тол	102	1 505	232	-1 273	15.4
- Үхэр	тол	2 885	3 388	161	-3 227	4.8
- Хонь	тол	2 631	13 474	1 508	-11 966	11.2
- Ямаа	тол	1 602	14 768	1 328	-13 440	9.0
Үүнээс: Өвчнөөр хоргдсон мал	тол	3 678	90	5	- 85	5.6
- Тэмээ	тол	-	-	-	-	-
- Адуу	тол	-	-	4	-	-
- Үхэр	тол	2 442	47	1	- 46	2.1
- Хонь	тол	1 194	40	-	-	-
- Ямаа	тол	42	3	-	-	-
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	11 224.0	13 918.7	11 213.9	-2 704.8	80.6
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая.төг	54 373.0	79 911.1	83 598.1	3 687.0	104.6

**I.1 ХӨДӨЛМӨР****I.1.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар**

Сум	2017		2018		2019	2019.III 2018.III %
	III	XII	III	XII	III	
Асгат	13	14	15	24	4	26.7
Баяндэлгэр	20	47	52	37	41	78.8
Дарьганга	38	27	38	29	31	81.6
Мөнххаан	56	49	75	64	31	41.3
Наран	20	16	53	23	29	54.7
Онгон	25	40	69	53	30	43.5
Сүхбаатар	31	56	57	92	62	108.8
Түвшинширээ	38	49	41	72	56	136.6
Түмэнцогт	26	59	45	23	56	124.4
Уулбаян	37	65	62	34	57	91.9
Халзан	14	15	31	13	39	125.8
Эрдэнэцагаан	28	178	156	17	100	64.1
Баруун-Урт	647	271	342	166	129	37.7
<b>Дүн</b>	<b>993</b>	<b>886</b>	<b>1 036</b>	<b>647</b>	<b>665</b>	<b>64.2</b>

**I.1.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр**

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр							Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник болон мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59
Асгат	4	4	-	2	-	1	1	-	-	-	2	1	1	-	-
Баяндэлгэр	41	17	-	3	1	2	18	11	5	1	8	14	10	9	-
Дарьганга	31	19	-	5	-	6	10	9	-	1	8	9	8	5	1
Мөнххаан	31	17	-	3	2	2	18	3	3	-	2	12	8	9	-
Наран	29	20	-	5	2	4	9	8	-	1	11	8	6	4	-
Онгон	30	16	-	6	-	1	20	3	-	-	5	14	5	5	1
Сүхбаатар	62	28	-	7	-	6	38	7	3	1	15	23	12	10	2
Түвшинширээ	56	28	-	11	1	7	18	12	6	1	18	17	14	7	-
Түмэнцогт	56	28	2	1	2	1	37	3	3	7	8	18	16	14	-
Уулбаян	57	28	-	5	1	2	27	9	11	2	11	27	11	8	-
Халзан	39	17	-	2	2	1	28	4	2	-	15	7	7	7	3
Эрдэнэцагаан	100	44	-	4	2	2	79	7	6	-	7	37	41	13	2
Баруун-Урт	129	58	4	40	5	17	45	14	4	-	25	65	20	18	1
<b>Дүн</b>	<b>665</b>	<b>324</b>	<b>6</b>	<b>94</b>	<b>18</b>	<b>52</b>	<b>348</b>	<b>90</b>	<b>43</b>	<b>14</b>	<b>135</b>	<b>252</b>	<b>159</b>	<b>109</b>	<b>10</b>



## I.1.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2017		2018		2019	2019.I-III 2018.I-III %
	I-III	I-XII	I-III	I-XII	I-III	
Асгат	55	192	23	175	6	26.1
Баяндэлгэр	33	152	13	117	55	4.2*
Дарьганга	16	63	30	123	28	93.3
Мөнххаан	50	165	44	239	14	31.8
Наран	49	211	51	153	48	94.1
Онгон	14	157	57	218	21	36.8
Сүхбаатар	23	237	7	154	5	71.4
Түвшинширээ	35	224	18	241	26	144.4
Түмэнцогт	10	128	42	199	52	123.8
Уулбаян	37	177	12	58	32	2.7*
Халзан	30	93	32	120	49	153.1
Эрдэнэцагаан	29	308	8	92	97	12.1*
Баруун-Урт	475	2 050	365	1 341	200	54.8
Дүн	856	4 157	702	3 230	633	90.2

## I.1.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО, сумаар

Сум	2017		2018		2019	2019.I-III 2018.I-III %
	I-III	I-XII	I-III	I-XII	I-III	
Асгат	45	114	-	71	4	-
Баяндэлгэр	14	68	-	39	11	-
Дарьганга	4	21	1	57	-	-
Мөнххаан	-	43	-	98	1	-
Наран	30	106	6	87	24	4.0*
Онгон	-	43	-	70	3	-
Сүхбаатар	3	83	-	41	1	-
Түвшинширээ	-	87	9	113	4	44.4
Түмэнцогт	-	12	7	40	1	14.3
Уулбаян	-	19	1	8	8	8.0*
Халзан	20	42	2	41	3	150.0
Эрдэнэцагаан	3	26	4	22	1	25.0
Баруун-Урт	60	460	32	251	20	62.5
Дүн	179	1 124	40	938	81	202.5



## I.1.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо		Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар											
			Уул уурхай, олборлолт	Боловсруулах үйлдвэр	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Мэдээлэл, холбоо	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Боловсрол	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	Бусад			
	2018 I-III	2019 I-III												
Асгат	-	2	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	1
Баяндэлгэр	-	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дарьганга	-	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	-	-
Наран	-	2	-	-	-	-	-	-	-	1	1	-	-	-
Онгон	-	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	-	-
Сүхбаатар	-	3	-	-	-	-	-	2	-	-	1	-	-	-
Түвшинширээ	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Түмэнцогт	1	6	1	-	-	-	4	-	-	-	-	-	-	1
Уулбаян	1	8	-	-	-	-	-	-	-	5	2	-	-	1
Халзан	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1
Баруун-Урт	86	31	-	-	31	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	89	56	1	1	31	4	2	-	-	8	4	1	1	4

**I.2 НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ****I.2.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ, сумаар, сая.төг**

Сум	Нийгмийн даатгалын шимтгэл				үүнээс: сайн дурын даатгал			
	2018.I-III	2019.I-III			2018.I-III	2019.I-III		
		Төл	Гүйц	%		Төл	Гүйц	%
Асгат	40.0	64.5	63.1	97.8	5.7	13.3	10.2	76.7
Баяндэлгэр	126.6	148.3	174.0	117.3	17.5	30.2	34.6	114.6
Дарьганга	85.0	98.6	118.9	120.6	13.6	20.7	22.1	106.8
Мөнххаан	97.4	129.7	155.3	119.7	13.5	27.0	31.9	118.1
Наран	63.0	63.5	67.9	106.9	9.3	15.6	14.9	95.5
Онгон	141.3	158.6	192.7	121.5	10.9	21.5	21.3	99.1
Сүхбаатар	79.3	107.9	112.3	104.1	9.8	19.7	20	101.5
Түвшинширээ	73.9	673.0	99.0	14.7	9.3	21.7	14.5	66.8
Түмэнцогт	100.7	137.4	83.7	60.9	10.9	15.5	18.1	116.8
Уулбаян	112.1	120.9	130.0	107.5	11.2	18.5	19.2	103.8
Халзан	54.8	64.6	72.6	112.4	5.1	10.8	8.3	76.9
Эрдэнэцагаан	212.9	235.0	290.5	123.6	26.7	40.1	45.0	112.2
Баруун Урт	1 968.6	732.4	2 582.4	352.6	63.2	80.5	108.2	134.4
Дүн	3 155.6	2 734.4	4 142.4	151.5	206.7	335.1	368.3	109.9

**I.2.2 ТЭТГЭВЭР ОЛГОЛТ, сумаар**

Сум	Тэтгэвэр авагчдын тоо				Олгосон тэтгэвэр, сая.төг			
	2017.I-III	2018.I-III	2019.I-III	%	2017.I-III	2018.I-III	2019.I-III	%
Асгат	238	249	255	102.4	152.4	204.6	126.8	62.0
Баяндэлгэр	537	586	613	104.6	403.0	493.5	580.9	117.7
Дарьганга	317	335	357	106.6	187.4	277.1	332.6	120.0
Мөнххаан	466	495	514	103.8	293.1	407.9	476.3	116.8
Наран	179	202	205	101.5	116.5	167.3	198.2	118.5
Онгон	461	477	493	103.4	341.8	448.0	508.8	113.6
Сүхбаатар	334	365	376	103.0	212.5	294.7	343.2	116.5
Түвшинширээ	349	362	377	103.9	221.2	291.7	341.4	117.0
Түмэнцогт	336	356	350	105.9	225.9	299.8	330.6	110.3
Уулбаян	352	368	383	95.1	235.0	303.4	360.6	118.9
Халзан	173	191	195	102.1	107.7	157.9	182.8	115.8
Эрдэнэцагаан	716	748	765	102.3	558.3	641.7	771.5	120.2
Баруун Урт	2 813	2 912	3 024	103.8	2 068.0	2 699.2	3 112.2	115.3
Дүн	7 271	7 646	7 907	103.4	5 122.8	6 686.8	7 665.9	114.6



## I.2.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая.төг

	2018.I- III		2019.I- III	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
<b>1 Халамжийн тэтгэвэр</b>	<b>1 132</b>	<b>424.6</b>	<b>1 175</b>	<b>559.4</b>
<b>2 Халамжийн тэтгэмж</b>	<b>741</b>	<b>104.2</b>	<b>588</b>	<b>114.2</b>
Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд 1 удаа	584	38.0	410	25.3
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	3	3.6	2	2.4
Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрхөд 1 удаа олгох тэтгэмж	5	6.0	5	6.0
Хорих ангис суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	1	1.2	4	4.8
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	148	55.4	167	75.7
<b>3 Амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	<b>899</b>	<b>151.5</b>	<b>900</b>	<b>183.4</b>
байнгын асаргаа шаардлагатай Ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	498	82	482	95.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	148	24.9	206	43.4
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	205	36.1	168	33.9
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	16	3.0	16	3.3
Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	9	2.2	10	3.3
Хүүхэд, төрөл садангүй ганц бие ахмад настан болон ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах	23	3.3	18	4
<b>4 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>0.5</b>
<b>5 Хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал</b>	<b>6 806</b>	<b>146.1</b>	<b>7 181</b>	<b>229.6</b>
<b>6 Ахмад настны нийгмийн хамгаалалын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт тусламж</b>	<b>224</b>	<b>37.3</b>	<b>2 636</b>	<b>68.0</b>
<b>7 Алдар цолтой ахмадуудад олгосон хөнгөлөлт тусламж</b>	<b>13</b>	<b>6.1</b>	<b>14</b>	<b>4.8</b>
<b>8 ХБ-тэй иргэнд олгогдож буй хөнгөлөлт, тусламж</b>	<b>283</b>	<b>37.4</b>	<b>326</b>	<b>35.0</b>
<b>9 Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж</b>	<b>3 906</b>	<b>442.9</b>	<b>4 134</b>	<b>516.7</b>
0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	2 990	357.4	3 268	425.8
Жирэмсэн эхийн тэтгэмж	865	69.9	780	60.4
Ихэр хүүхдийн тэтгэмж	6	12.0	2	4.0
3 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд 1 удаа	45	3.6	84	26.5
<b>10 Насны хишиг</b>	<b>2 201</b>	<b>185.2</b>	<b>2 366</b>	<b>195.2</b>
<b>11 Алдар эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж</b>	<b>4 734</b>	<b>657.5</b>	<b>4 889</b>	<b>671.9</b>
<b>ДҮН</b>	<b>20 939</b>	<b>2 192.8</b>	<b>24 210</b>	<b>2 578.7</b>

**I.3 ЭРҮҮЛ МЭНД****I.3.1 ЭРҮҮЛ МЭНД**

	Хэмжих нэгж	2018.I-III	2019.I-III	Өсөлт	
				тоо	хувь
1. Нийт үзлэг	мян.хүн	57.4	68.9	11.5	120.0
2. Ор хоног	мян.хүн	28.8	29.3	0.5	101.7
3. Урьдчилан сэргийлэх үзлэг	мян.хүн	13.6	24.8	11.2	182.4
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	3.5	3.5	-	100.0
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	4.8	5.2	0.4	108.3
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.2	1.1	-0.1	91.7
6. Осол гэмтлийн дуудлага	хүн	129	71	-58	55.0
7. Нийт нас баралт	хүн	85	87	2	102.4
8. Амаржсан эх	хүн	312	278	-34	89.1
Үүнээс: амьд төрсөн хүүхэд	хүн	312	280	-32	89.7
9. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	4	5	1	125.0
10. 1-5 хүртлэх насны эндсэн хүүхэд	хүн	-	-	-	-

**I.3.2. ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар**

Сум	Амаржсан эх	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
Асгат	-	-	-	-
Баяндэлгэр	3	3	-	-
Дарьганга	-	-	-	-
Мөнххаан	-	-	-	-
Наран	1	1	-	-
Онгон	3	3	-	-
Сүхбаатар	1	1	-	-
Түвшинширээ	1	1	-	-
Түмэнцогт	-	-	-	-
Уулбаян	1	1	-	-
Халзан	-	-	1	-
Эрдэнэцагаан	17	17	1	-
Баруун-Урт	251	253	3	-
<b>Дүн</b>	<b>278</b>	<b>280</b>	<b>5</b>	<b>-</b>



## I.3.3. ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ, сумаар

Халдварт өвчин	Хэмжих нэгж	2018.I-III	2019.I-III	Өсөлт	
				тоо	хувь
Вируст гепатит	хүн	-	1	-	-
Гар хөл амны өвчин	хүн	18	2	-16	11.1
Цусан суулга	хүн	1	9	8	9.0*
Бруцеллэз	хүн	-	1	-	-
Салхинцэцэг	хүн	93	126	33	135.5
Сүрьеэ	хүн	17	16	-1	94.1
Тэмбүү	хүн	36	73	37	202.8
Заг	хүн	20	26	6	130.0
Трихоминиаз	хүн	19	16	-3	84.2
Бусад	хүн	-	4	-	-
Бүгд	хүн	204	274	70	134.3

## I.3.4. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

